



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



# ИНФЛЯЦ, ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

ТАНИЛЦУУЛГА

2016

Инфляц, үнийн өөрчлөлтийн талаар танилцуулгатай холбоотой мэдээлэл ба санал хүсэлт байвал доорх хаяг болон веб сайтад хандана уу.

---

**Хаяг:** Засгийн газрын III байр,  
Бага тойруу -44, Улаанбаатар -11  
Монгол улс

**Вэб хаяг:** [www.nso.mn](http://www.nso.mn), [www.1212.mn](http://www.1212.mn)

### **Мэдээллээр үйлчилэх төв**

**Онлайн:** <http://web.nso.mn/onlinechat/index.php>

**Утас:** 1900-1212

### **Холбогдох мэргэжилтэн**

**Утас:** 51-261561 /Д.Батсүх, Ж.Болортуяа/

### **Зөвлөмж**

Энэхүү тайланд агуулагдсан бүх мэдээлэл Үндэсний статистикийн хороо мэдээллийн санд байдаг бөгөөд хувь хүн, албан байгууллага ямар нэгэн тусгай зөвшөөрөлгүйгээр бүрэн ашиглаж болно.

### **Мэдээллийн эх үүсвэр**

Энэхүү тайланд ашигласан өгөгдлүүд нь хэвлэгдэх үед гарах хамгийн сүүлийн үеийн тоон үзүүлэлтүүдийг тусгасан. Мэдээллийн эх үүсвэр нь худалдаа, үйлчилгээний цэгүүдээс цуглуулагдсан үнийн мэдээлэл юм.

### **Танилцуулгыг боловсруулсан:**

Эдийн засгийн статистикийн газар, Үнийн албаны шинжээч Ж.Болортуяа

## **АГУУЛГА**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	<b>3</b>
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	<b>4</b>
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	<b>5</b>
ОРШИЛ	<b>6</b>
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	<b>8</b>
БҮЛЭГ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС	<b>10</b>
1.1. ИНФЛЯЦ	<b>10</b>
1.2. ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ	<b>15</b>
БҮЛЭГ 2. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ИНФЛЯЦ	<b>21</b>
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	<b>25</b>

---

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн нэгдсэн улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ОПЕК	Газрын Тос Экспортлогч Орнуудын Байгууллага
ХЗХБҮА	Хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангилал
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ХҮУИ	Хэрэглээний үнийн улсын индекс
УБ	Улаанбаатар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

---

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Инфляцын түвшин, 2013-2016 оноор, хэрэглээний бараа, үйлчилгээний бүлгээр .....	10
Хүснэгт 2. Инфляцын жилийн дундаж түвшин, 2013-2016 .....	11
Хүснэгт 3. Бүсийн инфляцын жилийн түвшин, 2013-2016, хувь .....	12
Хүснэгт 4. Хэрэглээний үнийн индекс, өмнөх оныхтой харьцуулснаар, аймаг, нийслэлээр, 2013-2016, хувь .....	13
Хүснэгт 5. Хэрэглээний үнийн индекс, хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дэд бүлгээр, өмнөх оныхтой харьцуулснаар, 2013-2016, хувь .....	15
Хүснэгт 6. Улс орнуудын жилийн дундаж инфляцын түвшин (%), 2013-2016 оноор.....	22

---

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Инфляцын түвшин, сараар, өмнөх оны жилийн эцсийнхтэй харьцуулснаар.....	11
Зураг 2. Хэрэглээний үнийн индекс, өмнөх оныхтой харьцуулснаар, аймаг, нийслэлээр, 2016, хувь .....	14
Зураг 3. Өрхийн хэрэглээнд голлох хувийг эзэлдэг бараа, үйлчилгээний бүлгүүдийн харьцуулалт .....	15
Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100).....	16
Зураг 5. Хонины махны үнэ, ястай, кг, 2013-2016 он, сараар .....	17
Зураг 6. Төмс, хүнсний ногооны үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100) .....	17
Зураг 7. Төмсний үнэ, кг, 2013-2016 он, сараар .....	18
Зураг 8. Талх, гурил, будааны бүлгийн үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100) .....	19
Зураг 9. Гурилын үнэ, жилийн дунджаар, 2013-2016, төрлөөр .....	19
Зураг 10. Шатахууны үнэ, 2013-2016 оны сараар, төрлөөр .....	20
Зураг 11. Барааны дэлхийн зах зээлийн үнэ, доллар .....	21

## ОРШИЛ

2016 онд Монгол Улсын инфляцын түвшин хэд байсан, ямар төрлийн бараа, үйлчилгээний үнэ гол өөрчлөлтийг бий болгов, зарим гол нэр төрлийн барааны үнэ, түүний өсөлт, бууралт, мөн түүнчлэн глобал инфляцыг товчхон, ойлгомжтой байдлаар танилцуулах нь уг танилцуулгын зорилго юм.

Инфляцыг хэмжих хэд хэдэн арга байдгийн нэг нь хэрэглээний үнийн индекс юм. Инфляцын түвшинг тодорхойлох, төрөөс санхүү, мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх, хүн амын цалин, тэтгэвэр, тэтгэмж бусад орлогын хэмжээг индексжүүлэх тооцооны гол үзүүлэлт нь хэрэглээний үнийн индекс болдог. Түүнчлэн ХҮИ-ийг макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн нэг болох дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн аргын тооцоонд болон эцсийн ашиглалтын тооцооны өрхийн аж ахуйн эцсийн хэрэглээний зардлыг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхэд ашиглана.

Үндэсний Статистикийн Хороо нь өөрийн чиг үүргийн хүрээнд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээллийг сар бүр цуглуулж, хэрэглээний үнийн индексийг тооцон олон нийтийн хүртээл болгож байна.

Үндэсний Статистикийн Хороо 1991 оноос Олон Улсын Валютын Сангийн аргачлалаар ХҮИ-ийг тооцож эхэлсэн ба түүнээс хойш суурь, сагс, жинг 1995, 2000, 2005, 2010 онуудад шинэчилсэн. 1991-2006 он хүртэл Улаанбаатар хотын ХҮИ-ээр хэрэглээний үнийн улсын индексийг төлөөлүүлэн тооцдог байсан. 1997 оноос аймгуудын индексийг тусад нь тооцож, зарлаж ирсэн.

Манай улсын нутаг дэвсгэр, газар зүйн байршлаас хамаарч, бараа, үйлчилгээний үнэ, тариф аймгуудад харилцан адилгүй, улсын хэмжээний нийт өрхийн талаас илүү хувь нь аймаг, орон нутагт амьдардаг зэргээс шалтгаалан ХҮИ-ийн тооцоонд аймгийн ХҮИ-ийг оруулах шаардлагатай болсон. 2006 оны 1 дүгээр сараас эхлэн ХҮИ-ийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, олон улсын аргачлалын дагуу улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

2012 оны 1 дүгээр сараас эхлэн ХҮИ-ийг 2010 суурьт шилжүүлэн хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангиллын /ХЗХБҮА/ үндсэн 12 бүлгийн дагуу Улаанбаатар хотод 329 (аймгуудад 214 нэр төрөл) нэр төрлийн бараа, үйлчилгээгээр ХҮИ-ийг тооцож байна.

---

Махны дундаж үнийг илүү бодитой болгох үүднээс худалдааны зах, цэгүүдийн борлуулалтын хэмжээг тодорхойлох тусгайлсан судалгаа явуулж, үр дүнд нь махны дундаж үнийг жигнэж тооцдог болсон. Энэхүү арга зүйн өөрчлөлтийг ХҮИ тооцох аргачлалд тусган, 2014 оны 1 дүгээр сараас эхлэн шинэчилсэн аргачлалын дагуу тооцсон ХҮИ-ийг тархааж байна.



## ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Инфляц - Бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн ба үнэ нэмэгдэж, тэр хэмжээгээр мөнгөний ханш буурахыг инфляц гэнэ. Инфляц нь нэг талаас хэрэглээний сагсан дахь бараа, үйлчилгээний үнэ, өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний эрэлт, мөн тэдгээрийн нийлүүлэлт, хангамжийн харьцаа, нийт хэрэглээний зардалд эзлэх хувийн жинтэй холбогдон өөрчлөгдөх боловч нөгөө талаас мөнгөний нийлүүлэлт, валютын ханш, хүн амын орлогын өсөлт болон бусад хүчин зүйлүүд инфляцд нөлөөлдөг.

Хэрэглээний үнийн индекс - Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөр бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

Өрх болгон өөрийн зарлагын бүтэцтэй, түүнчлэн бараа, үйлчилгээний үнүүд нь ялгаатай хэмжээгээр өөрчлөгддөг учраас үнийн өсөлт өрх бүрт ижилхэн нөлөөлдөггүй. Хэрэв тухайн өрхийн мөнгөн зарлагын дийлэнх хувийг эзэлдэг бараа, үйлчилгээний үнэ өсвөл инфляцын нөлөөллийг ихээр мэдэрнэ. Харин үнэ нь харьцангуй тогтвортой бараа, үйлчилгээнд нийт зардлынхаа дийлэнх хэсгийг зарцуулсан бол тэр өрхөд үнийн өсөлтийн нөлөөлөл бага мэдрэгдэнэ.

Хэрэглээний сагс - Дундаж орлоготой өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. 2016 оны байдлаар Улаанбаатар хотын хэрэглээний сагс нийт 12 бүлгийн 329 бараа, үйлчилгээнээс, аймгийн сагс нийт 12 бүлгийн 214 бараа, үйлчилгээнээс бүрдэж байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин - Өрхийн худалдаж авсан бараа, үйлчлүүлсэн үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь юм. Бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт нь хэрэглэгчийн зарцуулсан зардлын дүнд хэрхэн нөлөөлөхийг энэ жин илэрхийлнэ.

Хүн амын тархалт, нас хүйсийн бүтэц, өрхийн орлогын түвшин, бараа, үйлчилгээний чанар зэрэг хүчин зүйлийн өөрчлөлтөөс өрхийн хэрэглээний бүтэц байнга өөрчлөгдөж байдаг. Үүнтэй уялдуулан хэрэглээний сагсны нэр төрөл болон бараа, үйлчилгээний жинг шинэчлэх шаардлагатай байдаг тул ҮСХ нь суурь үе, сагс, жинг 5 жил тутамд шинэчлэдэг.

---

| Суурь үе /суурь он/ - Индексийн утгыг нэгж буюу 100-тай тэнцүү гэж сонгож авсан үеийг хэлнэ.

Хэрэглээний үнийн индексийг өмнөх сарынхтай, өмнөх оны эцсийнхтэй, өмнөх оны мөн үеийнхтэй, суурь үетэй харьцуулсан байдлаар хугацааны хувьд 4 түвшинд тооцдог.

| Суурь инфляц<sup>1</sup> гэдэг нь хэрэглээний барааны сагснаас үнийн хэлбэлзэл ихтэй зарим барааг хасч үнийн түвшинг тооцсоныг хэлнэ. Ихэвчлэн хүнс болон түлш шатахууны үнийн савалгаанаас шалтгаалан зарим тохиолдолд төгрөгийн худалдан авах чадвар ХҮИ-т бодит тусгалаа олж чаддаггүй тул үнийн хэлбэлзэл ихтэй эдгээр бүлгүүдийг хасан суурь инфляцыг тооцдог байна.

| Дефляц - Инфляцын эсрэг үзэгдэл бөгөөд үнийн ерөнхий түвшин буурах үйл явц юм. Энэ үзэгдэл нь бараа, үйлчилгээг худалдан авах хүмүүсийн эрэлт, хэрэгцээ буурснаар үйлдвэрлэгч компаниудыг өөрсдийн бүтээгдэхүүнийг хямд үнээр борлуулж алдагдал хүлээхэд хүргэдэг.

| Өргөн хэрэглээний бараа, үйлчилгээ - Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-ны үр дүнд 0.2 болон түүнээс дээш хувийн жин эзэлж буй бараа, үйлчилгээг ойлгоно.

---

| <sup>1</sup> Төв банкнаас улирлын хэлбэлзэл ихтэй мах, сүү болон хүнсний ногооны дэд бүлгүүдийн ХҮИ-ийн сагснаас хасч инфляцыг дахин тооцож эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшин хаашаа хөдөлж байгааг тодорхойлдог.

## БҮЛЭГ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

### 1.1. ИНФЛЯЦ

Хэрэглээний үнийн улсын индекс өмнөх оныхоос 2013 оны эцэст 12.5 хувь, 2014 онд 11.0 хувь, 2015 онд 1.9 хувиар өссөн бол 2016 онд 1.1 хувиар өсч, өсөлтийн хурдац 2015 оныхоос 0.8 пунктээр саарлаа.


Хүснэгт 1. Инфляцын түвшин, 2013-2016 оноор, хэрэглээний бараа, үйлчилгээний бүлгээр хувь

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2013	2014	2015	2016	2013-2016 оны инфляц
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	13.3	8.4	-6.1	1.2	0.9
Согтууруулах ундаа, тамхи	3.2	13.4	10.3	1.4	2.7	0.6
Хувцас, бөс бараа, гутал	16.1	17.6	14.3	5.5	1.5	4.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	7.8	16.3	3.2	-0.9	2.3
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	18.2	11.5	5.1	1.4	0.9
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	13.2	9.1	4.1	5.7	0.6
Тээвэр	12.2	3.0	8.6	1.4	-0.8	1.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	-0.3	0.0	-0.8	0.1	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	0.3	8.1	2.4	0.2	0.2
Боловсролын үйлчилгээ	4.7	27.2	16.8	23.1	2.5	2.6
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	17.8	8.6	4.4	1.2	0.4
Бусад бараа, үйлчилгээ	4.1	17.2	11.8	5.1	3.1	0.8
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>12.5</b>	<b>11.0</b>	<b>1.9</b>	<b>1.1</b>	<b>14.4</b>

Инфляц 2016 оны жилийн эцэст 2013 оныхоос 14.4 хувиар өссөн байна. Үүний 4.0 нэгж (27.7 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөөс, 2.60 нэгж (18.1 хувь) нь боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс, 2.3 нэгж (15.8 хувь) нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс, 1.02 нэгж (7.1 хувь) нь тээврийн бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2016 онд 1.1 хувиар өсөхөд 0.3 нэгж (29.4 хувь) нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс, 0.3 нэгж (25.2 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөөс, 0.2 нэгж (16.4 хувь) нь эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Зураг 1. Инфляцын түвшин, сараар, өмнөх оны жилийн эцсийнхтэй харьцуулснаар



Инфляцын жилийн дундаж түвшин 2016 онд 1.1 хувь болж, 2015 оныхоос 6.2 дахин буурлаа.

Хүснэгт 2. Инфляцын жилийн дундаж түвшин, 2013-2016

Он	хувь			
	2013	2014	2015	2016
Инфляцын жилийн дундаж түвшин	10.5	12.8	6.6	1.1

2016 оны 8 сард ХҮҮИ 99.8 хувь гарсан нь 2016 оны хувьд хамгийн их бууралт буюу дефляци гарсан сар байв. 2016 оны 4 сард инфляц 102.1 хувь байсан нь хамгийн их өсөлт байлаа.

Бүсийн инфляц - Үндэсний Статистикийн Хороо нь бүсийн инфляцыг 2012 оноос эхлэн 2010 оны 12 дугаар сарын суурьтайгаар 4 бүсээр тооцон, нийтэд тархааж байна.

Хүснэгт 3. Бүсийн инфляцын жилийн түвшин, 2013-2016, хувь

<b>Бүс</b>	<b>2013</b>	<b>2014</b>	<b>2015</b>	<b>2016</b>
Баруун бүс	11.3	12.6	1.2	1.2
Хангайн бүс	14.1	12.7	4.3	1.8
Төвийн бүс	13.1	9.7	2.0	2.1
Зүүн бүс	10.7	11.2	3.4	1.6

Хангайн болон төвийн бүсийн инфляцын түвшин 2013 онд бусад онуудтай харьцуулахад хамгийн өндөр байсан бол төвийн болон зүүн бүсийнх 2014 онд бусад онуудынхаас өндөр байна. Төвийн бүсээс бусад бүсэд 2016 онд инфляцын түвшин хамгийн бага байлаа.

Бүсийн инфляцын түвшинг улсын түвшинтэй харьцуулахад, 2013 онд баруун болон зүүн бүсэд инфляцын түвшин 10.7-11.3 хувь байсан нь улсын инфляцын түвшинөөс 1.2-1.8 пунктээр доогуур, хангайн болон төвийн бүсэд 13.1-14.1 байсан нь улсын инфляцын түвшнээс 0.6-1.6 пунктээр өндөр байлаа. Харин 2014 онд улсын инфляцаас баруун, зүүн болон хангайн бүсийн инфляц 0.2-1.7 пунктээр өндөр, төвийн бүсийн инфляц 1.3 пунктээр доогуур байна. Баруун бүсийн инфляц 2015 онд улсын инфляцаас 0.7 пунктээр доогуур, харин бусад бүсийн инфляц 0.1-2.4 пунктээр өндөр байжээ. 2016 онд бүсүүдийн инфляцын түвшин улсын инфляцаас 0.1-1.0 пунктээр өндөр байв.


Хүснэгт 4. Хэрэглээний үнийн индекс, өмнөх оныхтой харьцуулснаар, аймаг, нийслэлээр, 2013-2016, хувь

Аймаг, нийслэл	2013	2014	2015	2016
<b>Ерөнхий индекс</b>	<b>112.5</b>	<b>111.0</b>	<b>101.9</b>	<b>101.1</b>
<b>Баруун бүс</b>				
Баян-Өлгий	115.0	111.2	96.2	101.8
Говь-Алтай	109.1	109.5	102.3	103.6
Завхан	115.1	110.0	104.1	101.2
Увс	108.8	115.2	103.2	101.0
Ховд	109.3	113.7	99.2	100.2
<b>Хангайн бүс</b>				
Архангай	108.7	117.1	111.9	106.1
Баянхонгор	114.5	112.3	106.4	100.7
Булган	121.6	110.4	101.7	101.7
Орхон	115.3	112.7	100.6	101.5
Өвөрхангай	116.6	112.9	107.0	100.8
Хөвсгөл	108.9	111.8	102.3	101.3
<b>Төвийн бүс</b>				
Говь-Сүмбэр	115.3	108.4	105.9	103.0
Дархан-уул	110.8	108.5	100.0	102.2
Дорноговь	118.6	110.3	97.7	102.0
Дундговь	114.4	111.2	104.0	105.5
Өмнөговь	116.1	109.9	101.4	100.5
Сэлэнгэ	108.1	110.6	102.4	101.4
Төв	112.8	109.4	106.1	102.9
<b>Зүүн бүс</b>				
Дорнод	110.7	110.7	105.4	101.7
Сүхбаатар	110.1	111.3	104.4	101.6
Хэнтий	111.2	111.9	100.2	101.5
<b>Улаанбаатар</b>				
<b>Улаанбаатар</b>	<b>112.3</b>	<b>110.7</b>	<b>101.1</b>	<b>100.5</b>

Аймгуудад хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2016 оны жилийн эцэст өмнөх оныхтой харьцуулахад аймгуудад 0.2-6.1 хувиар өссөний дотор Архангай аймагт 106.1 хувь нэмэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байв.

Харин Улаанбаатар хотод энэ үзүүлэлт 0.5 хувьтай гарлаа. Энэхүү өсөлтөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.4 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 7.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 2. Хэрэглээний үнийн индекс, өмнөх оныхтой харьцуулснаар, аймаг, нийслэлээр, 2016, хувь



## 1.2. ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ

Монгол Улсын өрхийн нийт хэрэглээний 29.3 хувийг эзэлдэг хүнсний барааны үнийн өөрчлөлт нь үнийн ерөнхий өөрчлөлтөнд шууд нөлөөлж байна. Өрхийн хэрэглээний зардлын хувийн жинг зарим бүлгээр харуулья /зураг 4./.

Зураг 3. Өрхийн хэрэглээнд голлох хувийг эзэлдэг бараа, үйлчилгээний бүлгүүдийн харьцуулалт



Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2015 онд 6.1 хувиар буурч байсан бол, 2013 онд 13.3 хувь, 2014 онд 8.4 хувь, 2016 онд 1.2 хувиар өсч байсан байна.

Хүснэгт 5. Хэрэглээний үнийн индекс, хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дэд бүлгээр, өмнөх оныхтой харьцуулснаар, 2013-2016, хувь

Бүлэг, дэд бүлэг	2013	2014	2015	2016
<b>ХҮНСНИЙ БАРАА, УНДАА, УС</b>	<b>113.3</b>	<b>108.4</b>	<b>93.9</b>	<b>101.2</b>
<b>Хүнсний бараа</b>	113.1	108.4	93.2	101.0
Талх, гурил, будаа	116.2	117.7	106.5	100.9
Мах, махан бүтээгдэхүүн	111.2	98.7	75.4	104.2
Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	120.0	114.1	92.1	101.3
Төрөл бүрийн өөх, тос	109.1	107.3	105.4	101.7
Жимс, жимсгэнэ	116.2	115.3	102.5	103.3
Төмс, хүнсний ногоо	108.9	112.9	104.0	84.4
Саахар, жимсний чанамал, чихэр, шоколад	108.5	109.1	102.0	110.1
Хүнсний бусад бүтээгдэхүүн	111.5	109.1	103.7	103.9
Согтууруулах бус ундаа	116.3	108.7	109.0	105.3




Монгол Улсын өрхийн хэрэглээнд хүнсний бараа, үүн дотор гурил, мах, махан бүтээгдэхүүн өндөр жин эзэлдэг. Үнийн өсөлтөд голлон нөлөөлдөг хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн, бензин, шатахуун зэрэг хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг авч үзье.

### Махны үнэ

Улаанбаатар хотын өрхийн хэрэглээний нийт мөнгөн зардлын 10.1 хувийг мах махан бүтээгдэхүүн эзэлдэг. Иймд инфляцын түвшин махны үнээс ихээхэн хамаардаг. Махны үнэ нийлүүлэлттэйгээ холбоотойгоор байнга хэлбэлздэг бөгөөд хавар, зуны улиралд өсч, намар, өвлийн улиралд буурдаг хандлага 2013-2016 онд мөн хэвээр хадгалагдав.


Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2016 оны бүх сард өмнөх оны эцсийнхтэй харьцуулахад 1.1-47.5 хувиар өссөн бөгөөд 5 сард 47.5 хувиар өссөн нь хамгийн өндөр өсөлттэй сар байлаа. 2016 оны 11 сард мах, махан бүтээгдэхүүний үнэ тухайн онд хамгийн бага өсөлттэй байжээ. Энэ нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн индекс өсөхөд голлон нөлөөлжээ.

Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100)



Өнгөрсөн дөрвөн жилд хонины махны 1 кг-ын үнэ хамгийн хямд буюу 2016 оны 12 дугаар сард 3946 төг байсан бол 2014 оны 5 дугаар сард хамгийн үнэтэй буюу 7800 төгрөгт хүрч байв.

Зураг 5. Хонины махны үнэ, ястай, кг, 2013-2016 он, сараар




Төмс, хүнсний ногооны үнэ

Сүүлийн жилүүдийн судалгаанаас харахад хавар, зуны улиралд хүнсний ногооны үнэ нь өсч, 8-10 дугаар сард ургац хураалттай холбоотойгоор үнэ нь хямдардаг.

2016 оны хувьд 7 дугаар сард төмс, хүнсний ногооны үнэ оны эхнээс 20.7 хувиар өссөн нь хамгийн их өссөн сар байлаа. /Зураг 7/.


Зураг 6. Төмс, хүнсний ногооны үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100)



Улаанбаатар хотод төмсний үнэ 2016 онд өнгөрсөн оны эцсийнхээс 30.7 хувь, луувангийн үнэ 37.6 хувь, манжингийн үнэ 26.6 хувь, байцааны үнэ 21.1 хувь, сонгины үнэ 1.4 хувиар буурсан нь төмс, хүнсний ногооны нийлүүлэлттэй холбоотой. Манай улс 2016 онд 94.4 мян.т хүнсний ногоо, 165.3 мян.т төмс хураасан нь 2015 оныхоос хүнсний ногоо 30.5 хувиар буюу 22.1 мян.тонноор, төмс 1.0 хувиар буюу 1.6 мян.тонноор өссөн байв.

Улаанбаатар хотын төмсний үнийн өсөлтийг өнгөрсөн 4 жилээр харахад 2013 онд хамгийн бага жил байсан ба хамгийн доод үнэ нь 670 төгрөгт хүрч байсан бол 2015 онд төмсний үнэ хамгийн өндөр байсан байна. 2015 оны 7 сард төмсний үнэ хамгийн өндөр буюу 1722 төгрөгт хүрчээ.

Зураг 7. Төмсний үнэ, кг, 2013-2016 он, сараар




### Гурилын үнэ

2016 оны байдлаар Талх, гурил, будааны бүлгийн үнэ 2015 оны жилийн эцсийнхээс 1.7 хувиар өсчээ.


Улаанбаатар хотод гурилын үнэ 2016 оны жилийн эцэст 2015 оны жилийн эцсийнхээс савласан дээдийн дээд гурилын үнэ 0.6 хувь, савласан дээд зэргийн гурилын үнэ 1.7 хувь, задгай 1-р зэргийн гурилын үнэ 1.6 хувь, савласан 2-р зэргийн гурилын үнэ 1.2 хувиар буурчээ.

Зураг 8. Талх, гурил, будааны бүлгийн үнийн улсын индекс  
(өмнөх оны 12 сар =100)



Энэхүү бууралт нь гурилын дотоодын үйлдвэрлэл, импортын тоо хэмжээний өөрчлөлт буюу нийлүүлэлттэй холбоотой. 2016 онд дотоодын гурил үйлдвэрлэлтийн хэмжээ 209.7 мян.тн байсан бөгөөд энэ нь 2015 оныхоос 1.5 хувиар өссөн. Гурилын импорт 2016 онд 30.0 мян.тн байсан ба 2015 оныхоос 46.5 хувиар өссөн байна.

Зураг 9. Гурилын үнэ, жилийн дунджаар, 2013-2016, төрлөөр



Жил бүрийн 8 дугаар сард их, дээд сургуулиудын сургалтын төлбөр нэмэгддэг нь өрхийн төсөвт хүндээр тусдаг. 2016 онд судалгаанд сонгогдсон төрийн өмчит их дээд сургуулийн сургалтын төлбөр өмнөх оныхоос өөрчлөлтгүй, харин хувийн их, дээд сургуулийн болон хувийн бага сургуулийн сургалтын төлбөр өмнөх оныхоос 3.4-6.3 хувиар нэмэгдсэн нь боловсролын бүлгийн үнийн дүнг 2.5 хувиар нэмэгдүүлсэн байна.


### Автобензин, шатахууны үнэ

Инфляцын өөрчлөлтөд бодитойгоор нөлөө үзүүлэгч нэг хүчин зүйл нь шатахууны үнийн өөрчлөлт юм. Улаанбаатар хотод АИ-80 бензины үнэ 2016 оны жилийн эцэст 2015 оны жилийн эцсийнхээс 6.5 хувь, АИ-92 бензины үнэ 7.8 хувь, дизель түлшний үнэ 8.4 хувиар буурчээ.

2016 оны 1 дүгээр сард шатахууны үнэ 2015 оны 12 дугаар сарын байдлаарх шатахууны үнээс 80-100 төгрөгөөр буурчээ. Мөн 2016 оны 5 болон 6 дугаар сард шатахууны үнэ дахин 20-50 төгрөгөөр буурсан ба үүнээс хойш он дуустал үнэ тогтвортой байжээ.

Бензин, шатахууны үнийн төлөөлөл болгож АИ-92-ын үнийн мэдээллийг авч үзье. 2013 оны 1 дүгээр сард үнэ хамгийн өндөр буюу 1 литр тутмын үнэ 1670 төг болж, 2016 оны 7 дугаар сард 1530 төгрөгт хүрсэн нь энэ дөрвөн жилийн хамгийн хямд үнэ байлаа.


Зураг 10. Шатахууны үнэ, 2013-2016 оны сараар, төрлөөр



## БҮЛЭГ 2. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ИНФЛЯЦ

2016 онд дэлхийн эдийн засгийн өсөлтийн хурд үргэлжлэн удааширсаар байв. ОУВС нь глобал эдийн засгийн өсөлт 2015 онд 3.2% байсан бол 2017 оны 1 сард 3.1% болсон гэж тооцжээ. Энэхүү өсөлтийг нь 2017 онд хөгжиж буй болон хөгжингүй орнуудын хувьд 3.4% хүрнэ гэж таамаглажээ. Түүхий эдийн ханшийг сэргээх нь 2017 онд байгалийн баялаг экспортлогч улс орнуудын хувьд дэмжлэг болно. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн удаашрал болон түүхий эдийн үнийн уналтын багахан сэргэлт нь бага хэмжээний тогтвортой инфляцын дарамтыг авчирсан. 2016 оны туршид глобал инфляц газрын тосны үнийн уналт нөлөөлжээ (зураг 14-ыг харна уу). Дэлхийн инфляц 2016 онд 2.9 хувьд хүрч, 2017 оны эцсээр эрчим хүчний үнийг сэргээхэд 3.3 хувиар өсөх төлөвтэй байна.

Зураг 11. Барааны дэлхийн зах зээлийн үнэ, доллар



Эх сурвалж: Bloomberg and Hamburg of International Economics

Газрын тосны үнэ 2016 оны 1 сард 33 доллар байсан бол 12 сард 55 доллар болж сэргэсэн байна. АНУ-ын газрын тосны компаниудын хөрөнгө оруулалт буурч, дэлхийн газрын тосны нийлүүлэлтийн тасалдалын тоо ихэссэнээс болж эхний хагас жилийн турш үнэ өсжээ. Жилийн эцэст ОПЕК-ийн нийлүүлэлтийн стратеги газрын тосны үнэд мэдэгдэхүйц нөлөөлжээ. 11-р сарын 30-нд, 2017 оны эхний хагаст ОПЕК-ийн гишүүдийн тоог (өдөрт 1.2 сая баррель) бууруулахаар шийдвэр гаргасны дараа нь Brent газрын тосны үнэ өссөн байна. Мөн ОПЕК болон зарим ОПЕК-ийн бус үйлдвэрлэгч нар үйлдвэрлэлийг цаашид бууруулахаар тохиролцжээ (өдөрт

0.6 сая баррелиар).

2016 онд газрын тосны бус бараа, бүтээгдэхүүний үнэ өссөн боловч хүнс болон металын салбарын үнэ буурчээ. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ цаг агаартай холбоотойгоор жилийн эхний хагаст өссөн боловч зуны улиралд улаан буудай, үр тарианы ургац, нийлүүлэлт элбэг байснаас шалтгаалан буурсан байна. Хятад улс металын хэрэглээг багасгах байгаль орчны бодлого явуулахаар болсон нь металын үнийг бага түвшинд барьжээ. Гэвч Хятад болон АНУ-д шинэ дэд бүтцийн хөрөнгө оруулалттай холбоотойгоор ирээдүйн эрэлт, хэтийн төлөв сайжирч, металын үнийг хэсэгчлэн сэргээсэн ажээ. Ерөнхийдөө хөгжингүй эдийн засагтай улс орнуудад аажмаар хаагдсан барааны хомсдол, хэд хэдэн хурдацтай хөгжиж буй эдийн засагтай орнуудын өрсөлдөх чадавхи суларч, газрын тосны болон бусад түүхий эдийн үнийн уналтаас үүдэлтэй бууралт нь 2016 оны хоёрдугаар хагаст дэлхийн инфляцд бага зэрэг дарамт учруулсан байна.

Хүснэгт 6. Улс орнуудын жилийн дундаж инфляцын түвшин (%), 2013-2016 оноор

Улс	2013	2014	2015	2016
Австрали	2.4	2.5	1.5	1.3
Австри	2.0	1.6	0.9	0.9
Бельги	1.1	0.3	0.6	2.0
Бразил	6.2	6.3	9.0	8.7
Канад	0.9	1.9	1.1	1.4
Швейцарь	-0.2	0.0	-1.1	-0.4
Чили	1.9	4.4	4.3	3.8
Хятад	2.6	2.0	1.4	2.0
Колумби	2.0	2.9	5.0	7.5
Коста Рика	5.2	4.5	0.8	0.0
Чех	1.4	0.3	0.3	0.7
Герман	1.5	0.9	0.2	0.5
Дани	0.8	0.6	0.5	0.3
Евро бүс (19 улс орон)	1.3	0.4	0.0	0.2
Испани	1.4	-0.2	-0.5	-0.2
Эстони	2.8	-0.1	-0.5	0.1
Европын холбоо (28 улс орон)	1.5	0.5	0.0	0.3
Финлянд	1.5	1.0	-0.2	0.4
Франц	0.9	0.5	0.0	0.2
Их долоо	1.3	1.6	0.2	0.8
Их Британи	2.6	1.5	0.0	0.7
Грек	-0.9	-1.3	-1.7	-0.8

Улс	2013	2014	2015	2016
Унгар	1.7	-0.2	-0.1	0.4
Индонез	6.4	6.4	6.4	3.5
Энэтхэг	10.9	6.4	5.9	4.9
Ирланд	0.5	0.2	-0.3	0.0
Исланд	3.9	2.0	1.6	1.7
Израиль	1.6	0.5	-0.6	-0.5
Итали	1.2	0.2	0.0	-0.1
Япон	0.3	2.8	0.8	-0.1
Солонгос	1.3	1.3	0.7	1.0
Литва	1.0	0.1	-0.9	0.9
Люксембург	1.7	0.6	0.5	0.3
Латви	0.0	0.6	0.2	0.1
Мексик	3.8	4.0	2.7	2.8
Нидерланд	2.5	1.0	0.6	0.3
Норвеги	2.1	2.0	2.2	3.6
Шинэ Зеланд	1.1	1.2	0.3	0.6
ЭЗХАХБ	1.6	1.7	0.6	1.1
ЭЗХАХБ - Европ	1.9	1.3	0.6	0.9
Польш	1.0	0.1	-0.9	-0.7
Португал	0.3	-0.3	0.5	0.6
Орос	6.8	7.8	15.5	7.0
Саудын Араб	3.5	2.7	2.2	3.5
Словак	1.4	-0.1	-0.3	-0.5
Словения	1.8	0.2	-0.5	-0.1
Швед	0.0	-0.2	0.0	1.0
Турк	7.5	8.9	7.7	7.8
Америк	1.5	1.6	0.1	1.3
Өмнөд Африк	5.8	6.1	4.5	6.6
Хөгжиж буй Азийн улсууд(45 улс орон)	3.8	3.0	2.2	2.5

2016 оны инфляцын жилийн дундаж түвшин Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага(ЭЗХАХБ)-ын улс орнуудад 1.1%, Европын холбооны улс орнуудад 0.3%, Евро бүсийн улс орнуудад 0.2% байлаа. Мөн Азийн Хөгжлийн банкны тооцоогоор хөгжиж буй Азийн улс орнуудын инфляцын дундаж түвшин 2016 онд 2.5% байв. Эдгээр өсөлтөд газрын тосны үнэ голлон нөлөөлсөн байна.



Зарим улсын инфляцыг товчхон авч үзье.

Америкийн нэгдсэн улсын инфляц 2016 онд 2.1%-д хүрчээ. Хүнс болон эрчим хүчийг оролцуулахгүйгээр 2016 оны инфляцыг тооцвол 2.2% байсан байна. Хүнсний бүлгийн барааны үнэ 0.2%-иар буурсан ба энэ нь 2009 оноос хойш үзүүлж байгаа анхны буурсан тохиолдол байв. Эрчим хүчний бүлгийн индекс 2014, 2015 онд буурсны эцэст 2016 онд 5.4%-иар өссөн байна. Энэхүү өсөлтөнд бензин, шатахууны үнэ 9.1%, байгалийн хий 7.8%, цахилгаан 0.7%-иар өссөн нь голлон нөлөөлжээ.

Япон улсын инфляцын жилийн дундаж түвшин 2016 онд -0.1% болж сөрөг үзүүлэлтэд хүрсэн нь дэлхийн зах зээл дээрх барааны үнэ буурч, иенийн ханш чангарснаас болжээ. Хүнс болон эрчим хүчийг оролцуулахгүйгээр 2016 оны инфляцыг тооцвол 0.6% байсан байна.

Их Британи улсын инфляцын түвшин 2016 онд 1.6% байжээ. Энэ нь хэдийгээр стерлингийн ханш суларч (европын холбооноос гарах санал хураалттай холбоотойгоор) байсан боловч 2014 оны 7 сараас хойш үзүүлж буй хамгийн өндөр өсөлт байлаа.

Хятад улсын инфляцын жилийн дундаж түвшин 2016 онд 2% болж өссөн байна. Харин өмнөх жилийн эцэстэй харьцуулахад инфляц 2.1% байжээ. Хүнсний бүлгийн барааны үнэ 2.4%, хүнсний бус бараа, үйлчилгээний үнэ 2.0%-иар өссөн байна. Барааны үнэ 1.8%, үйлчилгээний үнэ 2.5% -иар өсжээ.

Оросын холбооны улсын инфляцын түвшин 2016 онд шинэ үеийн түүхэн дэх хамгийн бага өсөлтийн рекорд тогтоож, 5.4% гарсан байна (хамгийн сүүлд 2011 онд инфляц 6.1% байсан нь сүүлийн хэдэн жил дэхь хамгийн бага үзүүлэлт байжээ). Энэ нь рублийн ханш чангарч, хэрэглэгчдийн эрэлт бага байгаагаас үүдэлтэй ажээ. 2016 онд хүнсний бүлгийн барааны үнэ 4.6%, хүнсний бус барааны үнэ 6.5%, үйлчилгээний үнэ 4.9%-иар өссөн байна.

Венесуэл улс нь дэлхийн хамгийн өндөр инфляцтай улс юм. Энэ улсын инфляц 2014 онд 68.5%, 2015 онд 270.7% байсан бол 2016 онд 800% -д хүрсэн байна. 2016 оны ДНБ өсөлт 19% -д хүрч эдийн засгийн тулаан хийж байна. Тус улсын экспортын орлогын 90 хувийг газрын тосны экспорт бүрдүүлдэг. Өөрөөр хэлбэл Венесуэл улсын валютыг хангадаг салбар нь газрыг тосны салбар юм. 2016 онд газрын тосны салбар 12.7%-иар, газрын тосны бус салбар 19.5%-иар тус тус буурсан байна. Газрын тосны үнэ доогуур байгаагийн улмаас иргэдийн хүнс хомсдож эмнэлгүүдэд эм, эмийн бэлдмэлийн хүрэлцээ багасч хүндрэл үүссэн байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Хэрэглээний үнийн индекс тооцох аргачлал, ҮСХ, 2016 он
2. Хэрэглээний үнийн индексийн 2013-2016 оны саруудын бюллетень танилцуулга, хүснэгтүүд
3. Хэрэглээний үнийн улсын индекс, ХЗХБҮА-ын 3 оронгийн түвшинд хүснэгтүүд
4. Улаанбаатар хотын бараа, үйлчилгээний үнэ
5. Инфляцын төлөв байдлын тайлан, 2017 он 3-р сар, Монгол банк
6. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан - <http://www.1212.mn/>
7. Монгол банкны сайт - <http://www.mongolbank.mn/>
8. Дэлхийн банкны сайт - <http://www.worldbank.org/>
9. ЭЗХАХБ-ын сайт, инфляцын дата - <https://data.oecd.org/price/inflation-cpi.htm>
10. Жилийн тайлан 2016, европын төв банк  
<https://www.ecb.europa.eu/pub/pdf/annrep/ar2016en.pdf>
11. Азийн хөгжил тойм, Азийн хөгжлийн банк, 2016 он  
<https://www.adb.org/sites/default/files/publication/182221/ado2016.pdf>
12. Азийн хөгжил тойм, Азийн хөгжлийн банк, 2017 он  
<https://www.adb.org/sites/default/files/publication/237761/ado-2017.pdf>
13. Хэрэглээний үнийн индексийн сарын мэдээ, АНУ-ын хөдөлмөрийн статистикийн товчоо, 2016 оны 12 сарын бюллетень  
[https://www.bls.gov/news.release/archives/cpi\\_01182017.pdf](https://www.bls.gov/news.release/archives/cpi_01182017.pdf)
14. Хэрэглээний үнийн индексийн сарын мэдээ, Их Британий үндэсний статистикийн товчоо, 2016 оны 12 сарын бюллетень  
<https://www.ons.gov.uk/economy/inflationandpriceindices/bulletins/consumerpriceinflation/dec2016>
15. Хэрэглээний үнийн индексийн сарын мэдээ, Хятадын үндэсний статистикийн товчоо, 2016 оны 12 сарын бюллетень  
[http://www.stats.gov.cn/english/pressrelease/201701/t20170111\\_1452528.html](http://www.stats.gov.cn/english/pressrelease/201701/t20170111_1452528.html)

16. Хэрэглээний үнийн индексийн сарын мэдээ, Оросын холбооны улсын статистикийн алба, 2016 оны 12 сар  
[http://www.gks.ru/bgd/free/B04\\_03/IssWWW.exe/Stg/d01/268.htm](http://www.gks.ru/bgd/free/B04_03/IssWWW.exe/Stg/d01/268.htm)
17. РосБизнесКонсалтинг Оросын хэвлэл, мэдээллийн сайтын мэдээ  
<https://www.rbc.ru/rbcfreenews/586639559a794721339224b4>
18. Статистикийн портал сайт - <https://www.statista.com/>